

БАТЛАВ
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА


Л. БААСАНЖАРГАЛ

БАТЛАВ
ЮНИВШИН ХХК, ОРОН НУТГИЙН
БИЗНЕСИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ


Г. ХОС-ЭРДЭНЭ

ОРОН НУТГИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2023 оны 10 дугаар
сарын 25 -ны өдөр

Дугаар: *ТТ/2023/01-17* Дархан-Уул аймаг

Энэхүү гэрээг нэг талаас орон нутгийн өмчийн өмчлөгч, аймгийн Орон нутгийн өмчийн газар (цаашид "ОНӨГ" гэх), түүнийг төлөөлж тус газрын мэргэжилтэн Л.Баасанханд нөгөө талаас өмч эзэмшигч байгууллага "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ (цаашид "түрээслүүлэгч" гэх), түүнийг төлөөлж тус байгууллагын дарга, нөгөө талаас Юнившин ХХК түүнийг төлөөлж Орон нутгийн бизнесийн газрын захирал Г.Хос-эрдэнэ (цаашид "түрээслэгч" гэх) нар (цаашид хамтад нь "талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үндэслэн байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго: Түрээслүүлэгч орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгө (цаашид "түрээсэлсэн эд хөрөнгө" гэх)-ийг (Гэрлийн шон) түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад хүлээлгэн өгөх, түрээслэгч нь уг гэрээнд дурдсан нөхцөлөөр түрээсийн төлбөр төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Түрээслүүлэгчийн эзэмшилд байгаа орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгө **564 ширхэг** шон байна./Ажил гүйцэтгэж дууссанаас хойш акт үйлдэж шонгийн тоог эцэслэнэ./

1.3. Түрээсийн гэрээний хугацаа: ОНӨГ-аас энэхүү гэрээг албан ёсоор баталгаажуулсан **2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс** эхлэн (**хоёр хүртэл жил**) буюу **2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр** хүртэл байна.

1.4. Түрээсийн гэрээг дүгнэх: Түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэн 3 хувь акт үйлдэнэ.


1.5. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газрыг түрээслүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх болон түрээсэлсэн эд хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх харилцааг энэхүү түрээсийн гэрээгээр зохицуулахгүй болно.

Хоёр. Эд хөрөнгө түрээслүүлэх, хүлээлцэх


2.1. Түрээслүүлэгч нь цаашид ашиглах боломжтой орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлнэ.

2.2. Түрээслүүлэгч, түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан 3 хувь акт үйлдэж хүлээлцэнэ. Түрээсэлсэн эд хөрөнгө хүлээлцсэн акт нь энэхүү түрээсийн гэрээний 1 дүгээр хавсралт


ОНӨГ-ыг төлөөлж


(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж


(З.Эрдэнэбат)

Түрээслэгч


(Д.Мөнхдэлгэр)

болно.

2.3. Түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 1.1-д заасан зориулалтын дагуу түрээсэлж, чанар байдлыг муутгахгүй (хэвийн элэгдэл хорогдлыг тооцохгүй)-гээр эзэмшиж ашиглах бөгөөд түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.4. Түрээсэлсэн эд хөрөнгийг бусдад дамжуулан түрээслэх, барьцаалах, шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

2.5. Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр түрээсэлсэн эд хөрөнгөд зөвхөн ОНӨГ-ын зөвшөөрлөөр хөрөнгө оруулалт хийж болно. Түрээсэлсэн эд хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх асуудлыг тусад нь гэрээгээр зохицуулна.

2.6. Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй харилцан тохиролцсоны дагуу барилгын үндсэн бүтэц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулахгүйгээр түрээсэлсэн эд хөрөнгийн өнгө үзэмжийг сайжруулах, нэмэгдүүлэх шаардлагаар өөрийн хөрөнгөөр урсгал засвар хийж болно. Энэ тохиолдолд ОНӨГ, түрээслүүлэгч нь засварын зардлыг хариуцахгүй, хөрөнгө оруулалтад тооцохгүй, түрээсийн төлбөрт суутгахгүй.

2.7. Түрээслүүлэгч, түрээслэгч нар түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтын зардлыг хэмжигдэхүйц байлгах арга хэмжээ авна.

Гурав. Төлбөр тооцоо, барьцаа

3.1. Энэхүү гэрээний 1.2-т заасан түрээсэлсэн эд хөрөнгийн 1 ширхэг, гэрэлтүүлгийн шонгийг төлбөр 1,500 / **нэг мянга таван зуун**/ төгрөг, 1 (нэг) сарын түрээсийн төлбөр нь ширхэг гэрэлтүүлгийн шон / / төгрөг болно.

3.2. Түрээсийн төлбөр нь ОНӨГ-аас тогтоосон төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэтэй уялдсан байна.

3.3. Түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 3 (гурав) сарын түрээсийн төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (.....) төгрөгийг барьцаа болгон энэхүү гэрээний хугацаанд хадгална.

Барьцаа байршуулах: Банкны нэр: Төрийн сан,

Дансны дугаар:

Мөнгөн дүн: төгрөг.

3.4. Түрээслэгч нь түрээсийн 1 сарын төлбөрийн 70 хувь болох 592,200 /**таван зуун ерэн хоёр мянга хоёр зуун**/ төгрөгийг урьдчилан тухайн сарын 05-ны өдрийн дотор түрээслүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

Түрээсийн төлбөр төлөх: Банкны нэр: Хаан банк

Дансны дугаар: 5108363490

Мөнгөн дүн: **592,200 төгрөг**

Түрээслүүлэгч, түрээслэгч нь түрээсийн төлбөр төлөх хуваарийг харилцан тохиролцоно. Түрээсийн төлбөр төлөх хуваарь нь энэхүү түрээсийн гэрээний 2 дугаар хавсралт болно.

3.5. Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 30 хувь болох 253,800 (**хоёр зуун тавин гурван мянга найман зуун**) төгрөгийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлнэ.

Түрээсийн орлого төвлөрүүлэх: Банкны нэр: Төрийн сан

Дансны дугаар: 100190051006

Мөнгөн дүн: **253,800 төгрөг**

ОНӨГ-ыг төлөөлж

(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж

(З.Эрдэнэбат)

Түрээслэгч

(Д.Мөнхдэлгэр)

3.6. Түрээсийн төлбөр нь түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашигласны төлөө түрээслэгчээс төлж буй төлбөр болно. Түрээсийн төлбөрт түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалт (цахилгаан, цэвэр, бохир ус, интернэт, телефон утас, кабелийн суваг, хог хаягдал, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, бусад)-ын зардал багтаагүй болно.

3.7. Түрээслэгч нь энэхүү гэрээнд заасан ашиглалтын зардлыг ханган нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу тогтоосон хугацаанд, бүрэн хэмжээгээр, зохих дансанд төлж барагдуулна.

3.8. Түрээсийн барьцаа нь гэрээний дагуу төлөх түрээсийн төлбөр, ашиглалтын зардалд хамаарахгүй болно.

3.9. Энэхүү гэрээний 1.4-т заасан гэрээ дүгнэсэн актад барьцаа хөрөнгийг түрээслэгчид шилжүүлэх эсэх талаарх үндэслэл, нөхцөлийг тодорхой заах бөгөөд түрээслүүлэгч, түрээслэгч нь барьцаа хөрөнгийг шилжүүлэхээр тохиролцсон бол барьцаа хөрөнгийн хэмжээ, хугацааг нэмж тусгана.

Дөрөв. ОНӨГ-ын эрх, үүрэг

4.1. Түрээсийн гэрээг хянан батлах, гэрээг нэг талын санаачилгаар, гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцлах эрхтэй.

4.2. Түрээсэлсэн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, түрээсийн төлбөр төлөлт, түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.

4.3. Түрээслүүлэгч түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 30 хувийг Төрийн сан банкинд энэхүү гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

4.4. Түрээсэлсэн эд хөрөнгөд зохих журмын дагуу хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгох, холбогдох гэрээг байгуулах, түүнд хяналт тавих эрхтэй.

4.5. Энэхүү гэрээний 5.7-д заасан саналыг судлан үзэж, 30 хоногт багтаан хариу өгөх үүрэгтэй.

4.6. Барилгын бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүй өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн тохиолдолд барилгыг хэвийн байдалд нь оруулах, учирсан хохирлыг арилгахыг түрээслэгчээс шаардах эрхтэй.

4.7. Түрээслүүлэгч, түрээслэгчээс гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих эрхтэй.

4.8. Түрээслэгчээс бусдад учруулсан хохирлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

4.9. Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

4.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

5.1. Түрээслэгчид түрээсэлсэн эд хөрөнгийг нэг бүрчлэн хүлээлгэн өгч, энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актад бүрэн тусгах үүрэгтэй.

5.2. Түрээслэгчийг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах үүрэгтэй.

5.3. Түрээслэгч эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хамгаалалтыг хариуцах, түрээсийн төлбөр, ашиглалтын зардал төлөх болон гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах эрхтэй.

5.4. Түрээслэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

5.5. Түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн

ОНӨГ-ыг төлөөлж


(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж


(З.Эрдэнэбат)

Түрээслэгч


(Д.Мөнхдэлгэр)

тохиолдолд түрээсийн гэрээг цуцлах саналаа Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх үүрэгтэй.

5.6. Түрээслэгчээс түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар тавьсан барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулахаас бусад саналыг судлан үзэж, ажлын 3 өдрийн дотор хариу өгөх үүрэгтэй.

5.7. Түрээслэгчийн барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах саналыг хүлээн аваад ажлын 3 өдрийн дотор Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх үүрэгтэй.

5.8. Түрээсэлсэн эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх, хувьчлах шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай түрээслэгчид ажлын 5 өдрийн дотор албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй. Шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоног өнгөрсний дараа түрээсийн гэрээг нэг талын санаачилгаар цуцалж болно.

5.9. Түрээсийн төлбөрийн зохих хувийг энэхүү гэрээнд заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй.

5.10. Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй бол энэхүү гэрээнд заасан алданги ногдуулж, төлүүлэх эрхтэй.

5.11. Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

5.12. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Зургаа. Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1. Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.

6.2. Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актаар хүлээн авах үүрэгтэй.

6.3. Түрээсэлсэн эд хөрөнгөд урсгал засварыг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Урсгал засвар гэдэгт барилга болон түүний тоног төхөөрөмжүүдийн их засвар хооронд барилга ашиглалтыг сайжруулахаар хийгдэж буй засварыг ойлгоно.

6.4. Түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.

6.6. Түрээслэгчийн буруутай үйл ажиллагаанаас түрээсэлсэн эд хөрөнгөд учирсан гэмтэл, эвдрэл, хохирлыг бүрэн хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах үүрэгтэй.

6.6. Түрээсэлсэн эд хөрөнгөд засвар хийх саналаа энэхүү гэрээнд заасны дагуу тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

6.7. Энэхүү гэрээнд заасны дагуу зохих зөвшөөрөл аваагүй хийсэн хөрөнгө оруулалт, засварын зардлыг гэрээ хэрэгжих хугацаанд болон гэрээ цуцалсны дараа буцаан авах болон шаардах эрхээ алдана.

6.8. Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

6.9. Түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээслэх, барьцаалах, бусдад шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

6.10. Түрээсийн хугацаа дуусгавар болоход өөрийн хөрөнгөөр авсан эд хогшил, тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчийн байр, эд хөрөнгийг сэвтээхгүй, гэмтээхгүй нөхцөлд салган авч болно.

6.11. Түрээсийн хугацаа дуусгавар болоход түрээсэлсэн эд хөрөнгийг түүнээс салгаж үл болох хөрөнгө оруулалт, засварын хамт түрээслүүлэгчид актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.12. Түрээсэлсэн эд хөрөнгөд хийсэн урсгал засвар, үйлчилгээний тайланг түрээслүүлэгчид тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.

ОНӨГ-ыг төлөөлж

Түрээслүүлэгчийг төлөөлж

Түрээслэрч

(Л.Баасанханд)

(З.Эрдэнэбат)

(Д.Мөнхдэлгэр)

6.13. Түрээсийн хугацаа дуусахаас өмнө гэрээг түрээслэгчийн санаачилгаар цуцалсан нөхцөлд барьцаа болон түрээсийн төлбөрийг шаардах эрхээ алдана.

6.14. Тухайн жилийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний засварыг хийх үүрэгтэй.

6.15. Шаардлагатай орон тоог бүрдүүлж, ажилчдын нийгмийн баталгааг хангаж, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах үүрэгтэй.

6.16. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Долоо. Талуудын хариуцлага

7.1. Энэ гэрээнд заасан нөхцөлийг зөрчсөн тал түүнээс болж нөгөө талд, бусдад учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

7.2. Талууд гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

7.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

7.4. Түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн, бусдад барьцаалсан, шилжүүлсэн, баталгаа гаргасан бол барьцаа нэхэмжлэх эрхээ алдана.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Гэрээг тайлбарлах болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

9.2. Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

9.3. Шаардлагатай бол эрх бүхий байгууллагаас гаргасан нотлох баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл байсан, мөн түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Арав. Гэрээг цуцлах болон нэмэлт, өөрчлөлт оруулах

10.1. ОНӨГ-аас түрээсийн гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар, түрээсийн гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцалж болно:

10.1.1. Түрээслэгч барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн;

10.1.2. Түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн, бусдад барьцаалсан, шилжүүлсэн, баталгаа гаргасан, дутагдуулсан, шамшигдуулсан;

10.1.3. Төрийн эрх бүхий байгууллагаас түрээсэлсэн эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, хувьчлахаар шийдвэрлэсэн;

10.1.4. Түрээслэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон;

ОНӨГ-ыг төлөөлж

Түрээслүүлэгчийг төлөөлж

Түрээслэгч

(Л.Баарсанханд)

(З.Эрдэнэбат)

(Д.Мөнхдэлгэр)

10.1.5. Түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашиглаагүй, түрээслүүлэгчийн тавьсан шаардлагыг үндэслэлгүйгээр 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй

10.1.6. Түрээсийн төлбөрийг 30 хоногоор хугацаа хожимдуулан төлсөн.

10.2. Түрээслэгчийн санаачилгаар түрээсийн гэрээг хугацаа дуусахаас өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд түрээсийн барьцаа, түрээсийн төлбөрийг түрээслэгчид олгохгүй болно.

10.3. Түрээслэгч энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах саналаа түрээслүүлэгчид 45 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

10.4. Гэрээг цуцлах саналаа нөгөө талдаа заавал бичгээр мэдэгдэнэ.

10.5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулна.

10.6. Энэхүү гэрээний нэмэлт, өөрчлөлт нь тус гэрээний салшгүй хэсэг байна.

10.7. Гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг санаачилсан тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Нөгөө тал нь саналыг зөвшөөрсөн эсэх тухай хариуг ажлын 10 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Бусад

11.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

11.2. Гэрээ нь 2 хавсралт, холбогдох бичиг баримтын хамт нийт () хуудас бөгөөд Монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, тал тус бүр 1 (нэг) хувийг хадгална. Гэрээний эх хувь нь хууль зүйн адил хүчинтэй байна.

11.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

11.4. Бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

11.5. Талууд гэрээний биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн нөхцөлд түрээсийн гэрээг мөн нөхцөлөөр 1 (нэг) жилээс илүүгүй хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

11.6. Энэхүү түрээсийн гэрээнд түрээслэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний цахим үнэмлэх, холбогдох тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг тус тус хавсаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Орон нутгийн өмчийн газрыг төлөөлж

Дархан хотын Тохижилт үйлчилгээний газрын дарга

Дархан-Уул аймгийн бизнес хариуцсан захирал

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
..... Л.Баасанханд
Утас: 99960393

З.Эрдэнэбат
Утас: 88881807

Д.Мөнхдэлгэр
Утас: 7777-8080
Мэйл хаяг: cmcteam@unitel.mn

ОНӨГ-ыг төлөөлж

Түрээслүүлэгчийг төлөөлж

Түрээслэгч

(Л.Баасанханд)

(З.Эрдэнэбат)

(Д.Мөнхдэлгэр)

Түрэсийн гэрээний дүгээр хавсралт.

ТҮРЭЭСЛЭСЭН ЭД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2023 ОНЫ 10-Р САРЫН 25-НЫ ӨДӨР

Дархан сумын 7 дугаар баг /Нарантолгой/

д/д	түрээслэсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ	ашиглалтанд орсон он	балансын үнэ төгрөг	өнгө үзэмж	чанар байдал	зориулалт	тайлбар
1	Гэрлийн шон	104			сайн	дунд	гэрэлтүүлэг	
2	Гэрлийн шон	92			сайн	дунд	гэрэлтүүлэг	10-р баг 23,25-р хороолол
3	Гэрлийн шон	368			сайн	дунд	гэрэлтүүлэг	13,14,15-г баг
4								
5								
	Нийт	564						

Энэхүү актад түрээслэсэн эд хөрөнгө бүрийн 4-н талаас авсан өнгөт фото зургийг хавсаргана

Хөрөнгө хүлээлгэн өгсөн
Түрээслүүлэгч

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч

ОНӨГ-ыг төлөөлж

(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж

(Э.Эрдэнэбат)

Түрээслэгч

(Д.Мөнхдалгэр)

Түрээсийн гэрээний 2 дугаар хавсралт.

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

2023 ОНЫ 10-Р САРЫН 25-НЫ ӨДӨР

д/д	Түрээслэсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ	Түрээсийн хэмжээ /төгрөг/	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 70%	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 30%-ОНӨГ	Түрээс төлөх огноо
1	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2023.08.05
2	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2023.09.05
3	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2023.10.05
4	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2023.11.05
5	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2023.12.05
6	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.01.05
7	Гэрлийн шон	564	846,00	592,200	253800	2024.02.05
8	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.03.05
9	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.04.05
10	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.05.05
11	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.06.05
12	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.07.05
13	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.08.05
14	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.09.05
15	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.10.05
16	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.11.05
17	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2024.12.05
18	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.01.05
19	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.02.05
20	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.03.05
21	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.04.05
22	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.05.05
23	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.06.05
24	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.07.05
	Гэрлийн шон	564	846,000	592,200	253800	2025.08.05
	нийт дүн					

Түрээслүүлэгч:

Түрээслэгч:

ОНӨГ-ыг төлөөлж

(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж

(З.Эрдэнэс)

Түрээслэгч

(Д.Мөнхдэлгэр)

ТТ/2023/01-12

тоот түрээсийн гэрээний 3 дугаар хавсралт.





ХАМРАХ ХҮРЭЭ



ТГ/2023/01-17

тоот түрээсийн гэрээний 4 дугаар хавсралт.

ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОН АШИГЛАСАН БАЙДАЛ



71/2023/01/17



тоот түрээсийн гэрээний 3 дугаар хавсралт.

ХАМРАХ ХҮРЭЭ



Т.Г. 2022.10.01.12

тоот түрээсийн гэрээний 4 дугаар хавсралт.

ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОН АШИГЛАСАН БАЙДАЛ



Эрхнийг үзэж
2024.02.08.
UNIVISION

он 2024 сар 02 өдөр 07
№ 074-174-009.
Дархан-Уул аймаг

ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ

Хүсэлт гаргах нь

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Юнивишн ХХК нь Дархан-Уул аймаг 5-р багт байрших Дэлгэрэх хүнс ХХК-руу сүлжээ оруулахтай холбоотойгоор гэрлийн 3 шонг ашиглах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг хүлээж авна уу.

Ашиглах 3 шонгийн байршлаа зургаар хавсаргав.

Хүндэтгэсэн,

Д.МӨНХДЭЛГЭР
ЮНИТЕЛ ХХК, ДАРХАН-УУЛ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БИЗНЕС ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

ЮНИТЕЛ ХХК

Хаяг: Дархан-Уул аймаг Дархан сум
10 баг буудай цэнгэр 3 дунд
МОНГОЛ-ОРЛОВ-ИНТЕРНЕТ-САТЕЛЛИТ

Утас: +976 7707 8989
Имэйл: info@unitel.mn Вебсайт: www.unitel.mn

6	объектуудын цахилгааны монтаж болон засвар үйлчилгээ хийх.	Объект хооронд явж байхдаа авто замын осолд өртөж эрүүл мэнд, амь насаараа хохирох	5	Б	24	Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх, орчныг хяналтандаа байлгах, анхаарал сарниулах зүйлтэй явахгүй байх	3	В	3
7	Автын цахилгааны үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ хийх	Машин механизмын халуун хэсэгт түлэгдэх, дайруулах, дарагдах	5	Б	24	Машин механизмын халуун хэсгүүд хөрсний дараа үзлэг хийж эхлэх, гар тормосыг ажиллуулсан байх, дугуйнд ивүүр хийх, данхратны хажууд нэмэлт тулаас хийх, жолооч бусад хүмүүстэй харилцаа	2	В	8
8		Толгой, хөл гараа цохиулах, хавчуулах	4	Б	21	Голгои хамгаалах хэрэгсэл, нүдний шил зүүх, хамгаалалтын хувцас хэрэгсэл тогтмол	2	А	15
9		Багаж хэрэгсэлийн эвдрэл гэмтлээс үүдэлтэй бэртэл гэмтэл авах	3	В	13	Ажил эхлэхээс өмнө багаж хэрэгсэлийг тогтмол шалгаж эвдрэл гэмтэл илэрсэн бол ашиглахгүй байх, зориулалтын багаж хэрэгсэл ашиглах.	1	В	4
10	Газар доогуур болон агаарын шугамын тасарсан утас залгах	Ажилчид болон бусад хүмүүс алхмын хүчдэлд нэрвэгдэх	5	В	22	Цахилгаан сүлжээний зургийг ажиглаж ойлгуулах, ажил эхлэхээс дуусах хүртэл удирдлагын болон хөндлөнгийн хяналттай ажиллах. Тухайн орчныг тусгаарлах, автомат салгуурыг салгаж, уг автоматыг цоожилж пайз өлгөсний дараа цахилгааны утсыг засварлах буюу залгах	2	В	8
11	Чийгшилтэй үед ажил гүйцэтгэх	Газар доогуур явсан кабель утас гэмтсэнээс хүчдэлд цохиулах	5	В	22	Тухайн хэсгийг хамгаалалтанд авч хүн нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, Хүчдэлээс бүрэн салгасны дараа засвар үйлчилгээ хийх, Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэх.	3	В	13
12	Ажлын дараа багаж хэрэгслээ хураах	Гараа шалбалах, хөл дээрээ юм алдаж унагах.	2	В	8	Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлээ бүрэн өмсөх, Багаж хэрэгслээ цэвэрлэж бүртгээд эмх цэгцтэй хураах.	1	В	4
13	Тухайн ажилласан ажлын орчноо цэвэрлэж хийх	Гараа шалбалах, хөл дээрээ юм алдаж унагах, бүдрэх, хальтрах, шороо тоосонд өртөх	2	В	8	Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлээ бүрэн өмсөх, хошууч макс зүүх, анхаарал болгоомжтой байх.	1	Г	2
өндөр эрсдэлтэй			17		дунд эрсдэлтэй			9	

икт олгох хэрэгтэй.

№	Хамгаалах хэрэгсэлийн нэр төрөл	Тайлбар
1	Толгойн хамгаалалт	Саравчтай болон ноосон малгайн дотор өмсөх зориулалттай хамгаалалт
2	Өвлийн ажлын хослол	Хөдөлгөөнд саад болохгүй, улирлын онцлогт тохирсон өмд, цамц байна.
3	Зуны ажлын хослол	
4	Ханцуйвч	Ханцуй тээглэх, саад болохоос хамгаалах зорилготой.
5	Нүдний шил	Цагаан өнгийн шил засвар үйлчилгээ хийх үед хэрэглэх.
6	Бээлий	Засвар үйлчилгээ хийхэд саад болохгүй байх зузаантай.
7	Цахилгааны хамгаалалтын бээлий	Цахилгаан тоноглолд засвар үйлчилгээ, холболт хийхэд хэрэглэх.

XAMPAX XYP33



БАТЛАВ
"ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛИЛГЭЭНИЙ ГАЗАР" ОНВАТЫГ
ГАЗРЫН ДАРГА
З.ЭРДЭНЗБАТ

АЖУУН БАЙРЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛТЭЭ

Байгууллын нэр: Дархан Хотын Тохижилтын Үйлчилгээний Газар
Ажлын байр: Цахилгаанчин

Огноо: 2024 оны 01 сарын 20-ны өдөр

№	Ажлын гүйцэтгэх ахлам	Бонусгүй аюул, үүсэх үр дараар	Үнэлэх үеийн		Ур дараар	Мараглал	Эрсдэлийн түвшин	Бүрүүрсны дараах
			Ур дараар	Мараглал				
1	Гэрээс ажиглалт ирэх, нээх	Гэрэлтүүлэх мүү, харахгүй гүйцэмж, талбайг бүтэрч, халтырч унах, нохойд хазуулах, таарх, халууцах	3	В	13	Эрсдэлийн түвшин	2	Б
2	Ажлын хувиас, хамгаалах хэрэгсэл шаардлага хангагдсан хөнгөн болон хүнд гэмтэх	Ажлын бараа, хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, өмнө тогтмол шалгах, шаардлага хангагдсан байх, хэрэгсэл өмсөж, зүүсэн байх	3	Г	9	Эрсдэлийн түвшин	2	Г
3	Ажиглалт гарахтай аюултай ажиглагчаас ялгах, сунгах гар хөнгө	Ажлын хувиас, хамгаалах хэрэгсэл шаардлага хангагдсан хөнгөн болон хүнд гэмтэх	4	В	18	Эрсдэлийн түвшин	2	В
4	Өндрийн ажиглагч шаардлага хангагдсан хөнгөн	Өндрийн ажиглагч шаардлага хангагдсан хөнгөн болон хүнд гэмтэх	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В
5	Өдрийн ажиглагч шаардлага хангагдсан хөнгөн	Өдрийн ажиглагч шаардлага хангагдсан хөнгөн болон хүнд гэмтэх	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В
6	Хэрэгсэлийн цахилгаан тоног	Хэрэгсэлийн цахилгаан тоног	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В
7	Хэрэгсэлийн цахилгаан тоног	Хэрэгсэлийн цахилгаан тоног	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В
8	Хэрэгсэлийн цахилгаан тоног	Хэрэгсэлийн цахилгаан тоног	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В
9	Хэрэгсэлийн цахилгаан тоног	Хэрэгсэлийн цахилгаан тоног	5	В	22	Эрсдэлийн түвшин	3	В

ТҮРЭЭСЭЛСЭН ЭД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2024 оны 11-р сарын 19-ний өдөр

Дархан-Уул аймаг, Дархан сум

д/д	Түрээслэсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ	Өнгө үзэмж	Чанар байдал	Зориулалт	Тайлбар
1	Гэрэлтүүлгийн шон	92	сайн	Дунд	гэрэлтүүлэг	25-р хороолол
2	Гэрэлтүүлгийн шон	1,008	сайн	Дунд	гэрэлтүүлэг	7-р баг
3	Гэрэлтүүлгийн шон	1,773	сайн	Дунд	гэрэлтүүлэг	13,14,15-р баг
4	Гэрэлтүүлгийн шон	1,343	сайн	Дунд	гэрэлтүүлэг	1,2,3 баг Дэрэвон
5	Гэрэлтүүлгийн шон	318	сайн	Дунд	гэрэлтүүлэг	5 баг
6	Гэрэлтүүлгийн шон	419	сайн	Дунд	гэрэлтүүлэг	6-р баг болон /брак байр/
7	Гэрэлтүүлгийн шон	347	сайн	Дунд	гэрэлтүүлэг	8 баг
8	Гэрэлтүүлгийн шон	125	сайн	Дунд	гэрэлтүүлэг	18 баг хөтөл хороолол
9	Нийт	5,425				

Энэхүү актад түрээслэсэн эд хөрөнгө бүрийн 4 талаас авсан өнгөт фото зургийг хавсаргана.

Хөрөнгө хүлээлгэн өгсөн түрээслүүлэгч:

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч:
Юнйишин ХХК, Дархан-Уул аймгийн Бизнес хариуцсан захирал:

..... Д.Мөнхдэлгэр

Өрхийн борлуулалтын ахлах мэргэжилтэн:

..... Б.Отгоннахиа

Төлөвлөлт ашиглалтын инженер:

..... Э.Энхбат

ОНӨГ-ыг төлөөлж

.....
(Э.Оюунсүрд)

Түрээслүүлэгчийн төлөөлж

.....
(З.Бүрдэнэс)

Түрээслэгч

.....
(Д.Мөнхдэлгэр)

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

2024 оны 11-р сарын 19-ний өдөр

2024 он

Сар	Түрээслэсэн эд хөрөнгийн нэр	Өмнөх гэрэлтүүлгийн шон	Нэмэгдсэн гэрэлтүүлгийн шон	Сард тоологдсон гэрэлтүүлгийн шон	Түрээсийн хэмжээ - 1 /төгрөг/	Түрээсийн хэмжээ- 2 /төгрөг/	Түрээсийн хэмжээ- зөрүү /төгрөг/	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 70%	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 30%- ОНӨГ
4-р сар	Гэрэлтүүлгийн шон	674	3230	3904	1,011,000	5,856,000	4,845,000	3,391,500	1,453,500
5-р сар	Гэрэлтүүлгийн шон	3230	1396	4626	1,011,000	6,939,000	5,928,000	4,149,600	1,778,400
6-р сар	Гэрэлтүүлгийн шон	4626		4626	1,011,000	6,939,000	5,928,000	4,149,600	1,778,400
7-р сар	Гэрэлтүүлгийн шон	4626		4626	1,011,000	6,939,000	5,928,000	4,149,600	1,778,400
8-р сар	Гэрэлтүүлгийн шон	4626		4626	1,011,000	6,939,000	5,928,000	4,149,600	1,778,400
9-р сар	Гэрэлтүүлгийн шон	4626	799	5425	1,011,000	8,137,500	7,126,500	4,988,550	2,137,950
10-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425		5425	1,011,000	8,137,500	7,126,500	4,988,550	2,137,950
11-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425		5425	1,011,000	8,137,500	7,126,500	4,988,550	2,137,950
12-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425		5425		8,137,500	8,137,500	5,696,250	2,441,250
	Нийт				8,088,000	66,162,000	58,074,000	40,651,800	17,422,200

ОНӨГ-ыг төлөөдөг

(Э.Оюунсүвд)

Түрээслүүлэгчийг төлөөлөгч

(З.Эрдэнэбат)

Түрээслэгч

(Д.Мөнхдалай)

2025 он

Сар	Түрээслэсэн эд хөрөнгийн нэр	Гэрэлтүүлгийн шон тоо	Түрээсийн хэмжээ /төгрөг/	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 70%	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 30%-ОНӨГ
1-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
2-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
3-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
4-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
5-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
6-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
7-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
8-р сар	Гэрэлтүүлгийн шон	5425	8,137,500	5,696,250	2,441,250
	Нийт		65,100,000	45,570,000	19,530,000

Хөрөнгө хүлээлгэн өгсөн түрээслүүлэгч:

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч:
Юнъяншин ХХК, Дархан-Уул аймгийн Бизнес хариуцсан захирал

..... Д.Мөнхдэлгэр

Өрхийн бэрлүүлэлтийн ахлах мэргэжилтэн:

..... Б.Отгоннахна

Төлөвлөлт ашиглалтын инженер:

..... Э.Энхбат

ОНӨГ-ыг төлөөлж

(З.Оюунсүрд)

Түрээслүүлэгчийн төлөөлж

(З.Бүрдэнэбат)

Түрээслэгч

(Д.Мөнхдэлгэр)

Хамрах Хүрээ: 8-р баг Манхантолгой, Дэвшил



Хамрах Хүрээ: 1,2,3-р багууд Дэрэвэн



Хамрах хүрээ: 5-р баг



Хамрах хүрээ: 18-р баг хотол хороолол



Хамрах Хүрээ: 6,8-р баг 7-р баг Нарантолгой




Хамрах Хүрээ: 6,8-р баг 7-р баг Нарантолгой



Хамрах Хүрээ: 15-р баг Батлион, Хабитат





ТҮРЭЭСЭЛСЭН ЭД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2024 оны 1-р сарын 29-ний өдөр

Дархан сумын 7-р баг /Нарантолгой/

д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбай н хэмжээ	Ашиглалтад орсон он	балансын үнэ төгрөг	Өнгө үзэмж	Чанар байдал	Зориулалт	Тайлбар
1	Гэрлийн шон	92			сайн	Дунд	гэрэлтүүлэг	25-р хороолол
2	Гэрлийн шон	198			сайн	Дунд	гэрэлтүүлэг	7-р баг
3	Гэрлийн шон	377			сайн	Дунд	гэрэлтүүлэг	13,14,15-р баг
4	Гэрлийн шон	7			сайн	Дунд	гэрэлтүүлэг	6-р баг /брак байр/
6	Нийт	674						

Энэхүү актад түрээсэлсэн эд хөрөнгө бүрийн 4 талаас авсан өнгөт фото зургийг хавсаргана.

Хөрөнгө хүлээлгэн өгсөн түрээслүүлэгч:

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч:
Дархан /Сэлэнгэ аймаг бизнес хариуцсан захирал

..... Д.Мөнхдэлгэр



ОНӨГ-ыг төлөөлж

(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөлж



Түрээслэгч

.....

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

2024 оны 1-р сарын 29-ний өдөр

д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ	Түрээсийн хэмжээ /төгрөг/	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 70%	Түрээсийн хэмжээ /төгрөг/ 30%- ОНӨГ	Түрээс төлөх огноо
1	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2023-11
2	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2023-12
3	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-01
4	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-02
5	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-03
6	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-04
7	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-05
8	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-05
9	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-06
10	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-07
11	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-08
12	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-09
13	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-10
14	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-11
15	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2024-12
16	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-01
17	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-02
18	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-03
19	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-04
20	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-05
21	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-06
22	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-07
23	Гэрлийн шон	674	1,011,000	707,700	303,300	2025-08
	нийт дүн					

Хөрөнгө хүлээлгэн өгсөн түрээслүүлэгч:

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч:
Дархан, Сэлэнгэ аймаг бизнес хариуцсан
захирал

Д.Мөнхдэлгэр

ОНӨГ-ыг төлөөлж

(Л.Баасанханд)

Түрээслүүлэгчийг төлөөрж

Түрээслэгч